



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/381

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, 16.1.5, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоол, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын А/42 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын биет бус өвийн үзлэг, тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Даваадамдин (Аймгийн Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Г.Нарангэрэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Зулзаяа (Аймгийн Төв музейн бүртгэл мэдээллийн ажилтан)

Б.Болорцэцэг (Аймгийн Соёл урлагийн газрын Урлаг, уран бүтээл хариуцсан мэргэжилтэн)

(Сумдын Соёлын төвийн дарга нар)

Нарийн бичгийн дарга:

Л.Баасансүрэн (Аймгийн Соёл урлагийн газрын Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Соёлын биет бус өвийн үзлэг, тооллогын цахим судалгааг 2022 оны 11 дүгээр сарын 12-ны дотор, хээрийн судалгааг 2023 оны 10 дугаар сарын 15-ны дотор багтаан зохион байгуулж холбогдох газарт тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Даваадамдин)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Цэцэгмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН